



Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Хөтөлбөр: **Авто инженер 071601**

Үйлдвэрлэлийн автоматжуулалт 071402

Металл боловсруулах технологи 071502

Шинжээчийн баг:

Ахлагч: Т.Соронзонболд

Гишүүд: Ж.Мөнгөн

Л.Алтангэрэл

Д.Сарангэрэл

2020.06.17

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1-а. Авто инженер хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 1-б. Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн төлөвлөлт

шалгуур 1-в. Металл боловсруулах технологи хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар:

ШУТИС - Шинжлэх ухаан технологийн их сургууль

БСШУСЯ - Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ХААИС - Хөдөө аж ахуйн их сургууль

МУИС – Монгол улсын их сургууль

БМИҮЗ - Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

ҮДСБ - Үр дүнд суурилсан боловсрол

МехТС - Механик тээврийн сургууль

ДБШТ- Дээд боловсролын шинэчлэлийн төсөл

CDIO – Conceive Design Implement Operate – Сэтгэх, Зохиох, Бүтээх, Хэрэглэх

PESTLE-Political, Economic, Social, Technological, Legal and Environmental analysis - Улс төр, Нийгэм, Технологи, Хууль эрх зүй, Хүрээлэн буй орчны үр нөлөөг тооцох чиг хандлагын шинжилгээний арга.

PEOs - Program Educational Objectives - Хөтөлбөрийн боловсролын зорилтууд

PLOs - Program Learning Outcomes - Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд

CLOs - Course Learning Outcomes - Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургууль /Монгол, Англи/	ШУТИС-ийн Механик тээврийн сургууль School of Mechanical Engineering and Transportation, MUST	
Хөтөлбөр /Монгол, Англи/	Авто инженер Үйлдвэрлэлийн автоматжуулалт Металл боловсруулах технологи	Automotive Engineering Industrial Automation Metal Processing Technology
Индекс	071601 071402 071502	
Шинжээчид	Т.Соронзонболд Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дэд захирал Ж.Мөнгөн ХААИС-ийн Инженер технологийн сургуулийн захирал Л.Алтангэрэл МГТИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал Д.Сарангэрэл МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Химийн тэнхимийн профессор	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Тунгалаг	
Төлөвлөгөө	Огноо	Хийгдсэн байх ажлууд
	2019.05.25	Шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилгүй эсэхийг баталгаажуулах
	2019.05.28	Шинжээчдийн багийн томилж, гэрээ байгуулан, өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх
	2019.06.04	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2019.06.08	Мэргэжилтэн, шинжээчийн багийн ахлагч сургуульд очиж бэлтгэл хангуулах
	2019.06.09, 10,11	Шинжээчид сургуульд очиж ажиллах
	2019.06.17	Шинжээчид үнэлгээний тайлан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2019.06.18	Шинжээчийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авна
	2019.06.19	Сургууль санал, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.06.20	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчийн үнэлгээний тайланг хэлэлцүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

1. АВТО ИНЖЕНЕР

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж		ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн тэнхим				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо		1962				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр		АВТО ИНЖЕНЕР				
Хөтөлбөрийн индекс		071601				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа		2024				
Сургалтын хэлбэр		Өдөр				
Суралцах хугацаа		4 жил				
Сургалт явуулдаг хэл		Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)		2016 он “АВТО ИНЖЕНЕР” D071601				
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:		2016 он 6 дугаар сарын 27				
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:		13				
Үүнээс	Үндсэн	13				
	Цагийн					
	Бусад					
Боловсролын зэрэг	Доктор	7				
	Магистр	5				
Албан тушаалын зэрэглэл	Профессор	3				
	Дэд профессор	2				
	Ахлах багш	6				
	Багш	2				
	Дагалдагч багш					
Ажлын туршлага	20-оос дээш жил	7				
	11-20	3				
	6-10 жил	3				
	5 хүртэлх жил					
Суралцагчдын нийт тоо		2020	2019	2018	2017	2016
Үүнээс	4-р курс		32	39	73	63
	3-р курс		35	32	39	73
	2-р курс		89	35	32	39
	1-р курс		97	89	35	32
Төгсөгчдийн тоо			39	73	63	63
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг		Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Энгельсийн гудамж, Механик тээврийн сургууль				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар		МехТСургуулийн захирал: Д.Цолмонбаатар, 99081904 Тээврийн Салбарын эрхлэгч: И.Базаррагчаа 99181602				
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:		Анх удаа				

1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж		ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн Механик мехатроникийн салбар				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо		2014 оноос (яг энэ нэрээр анх элсэлт авч эхэлсэн)				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр		Үйлдвэрлэлийн автоматжуулалт				
Хөтөлбөрийн индекс		071402				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа		2024				
Сургалтын хэлбэр		Өдөр				
Суралцах хугацаа		4 жил				
Сургалт явуулдаг хэл		Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)		Үйлдвэрлэлийн автоматжуулалт, 071402, 2014 оноос				
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:		Хөтөлбөрийн дэд хороогоор 2014 оны 6-р сарын 12 Хөтөлбөрийн ерөнхий хороогоор 2014 оны 6-р сарын 15				
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:		МехТС-д нийт ... багштай бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ММСалбарт 12 профессор багш нартай байна.				
Үүнээс	Үндсэн	10 багш				
	Цагийн					
	Бусад	2 багш (Зөвлөх профессороор Ш.Бямбаа, П.Аюурзана нар ажиллаж байна.)				
Боловсролын зэрэг	Доктор	4				
	Магистр	6				
Албан тушаалын зэрэглэл	Профессор					
	Дэд профессор	5				
	Ахлах багш	1				
	Багш	4				
Ажлын туршлага	Дагалдагч багш					
	20-оос дээш жил	4				
	11-20	1				
	6-10 жил	3				
	5 хүртэлх жил	2				
Суралцагчдын нийт тоо		2020	2019	2018	2017	2016
		137	169	221	191	185
Үүнээс	36	16	57	27	26	
	46	43	38	59	29	
	43	56	44	45	70	
	12	54	84	60	59	
Төгсөгчдийн тоо		15	26	13	34	21
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг		Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Энгельсийн гудамж, Механик тээврийн сургууль				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар		МехТСургуулийн захирал: Д.Цолмонбаатар, 99081904 ММСалбарын эрхлэгч: Д.Ганбат, 99019277				
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:		Анх удаа				

2. МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж		ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн тэнхим				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо		1987				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр		Метал боловсруулах технологи				
Хөтөлбөрийн индекс		071502				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа		№960009, 2020 оны 3-р сарын 02 Хүчинтэй хугацаа 5 жил				
Сургалтын хэлбэр		Өдөр				
Суралцах хугацаа		4 жил				
Сургалт явуулдаг хэл		Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)						
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:		2016 оны 6-р сарын 27-ны өдрийн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар				
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:		15				
Үүнээс	Үндсэн	15				
	Цагийн					
	Бусад					
Боловсролын зэрэг	Доктор	6				
	Магистр	9				
Албан тушаалын зэрэглэл	Профессор	4				
	Дэд профессор	1				
	Ахлах багш	3				
	Багш	5				
	Дагалдагч багш					
Ажлын туршлага	20-оос дээш жил	4				
	11-20	2				
	6-10 жил	6				
	5 хүртэлх жил	1				
Суралцагчдын нийт тоо		2020	2019	2018	2017	2016
Үүнээс	4-р курс					
	3-р курс					
	2-р курс					
	1-р курс					
Төгсөгчдийн тоо			20	24	40	17
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг		Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Энгельсийн гудамж, Механик тээврийн сургууль				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар		МехТСургуулийн захирал: Д.Цолмонбаатар, 99081904 Салбарын эрхлэгч: О.Галаа				
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:		Анх удаа				

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур 1-А. АВТО ИНЖЕНЕР ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

CDIO сургалтын аргад тулгуурласан мэргэжилтний загварыг “Мэргэжлийн сэтгэлгээ, ур чадвар, харилцааны ур чадвар, шинжлэх ухааны аргуудыг ашиглаж чаддаг, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах “энтрепренёр” мэргэжилтэн” байхаар загварчлан баталгаажуулсан.

Хөтөлбөрийг АНУ-ын Веллорын технологийн институт, Миннесотагийн үндэсний сургуулийн хөтөлбөр, Японы Нагоягийн их сургууль, Энэтхэгийн CPM их сургууль, ОХУ-ын Москвагийн авто-замын техникийн их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулж үнэлэлт дүгнэлт хийсэн байна.

Харьцуулалт хийхдээ хөтөлбөрийн бүтэц, зорилго, зорилт, сургалтын төлөвлөгөөний хичээлийн кредит цагийн хуваарилалт, онол, дадлагын харьцаа зэрэг үзүүлэлтийг гол үзүүлэлт болгон авч үзжээ.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Уг хөтөлбөр нь “Авто инженер” мэргэжилтэн бэлтгэж байгаа төрийн болон хувийн өмчийн их дээд сургуулиудын жишиг хөтөлбөр болж байна.

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо нөхцөл байдлын STEEP шинжилгээ хийсэн.

Хөтөлбөрт үр дүнд суурилсан сургалтын арга болох CDIO-ийн загварыг ашигласан туршлагатай.

Хөтөлбөрийн хороо, дэд хороо нь тус сургуулийн профессор, багш нараас бүрдсэн бөгөөд тулгамдаж байгаа асуудлаа хуралдааны журмаар шийдвэрлэж тогтмолжсон.

Мэргэжлийн холбооны оролцоог хангаж хөтөлбөрийн зорилго, зорилт хэрхэн хангагдаж байгаа тал дээр дүгнэлт гаргуулан цаашид ажилдаа тусган ажиллаж байна.

Сул тал: Салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо Авто замын сүлжээ, Тээврийн хэрэгслийн бүртгэл, Зорчигч тээврийн үндсэн үзүүлэлтийг гол үзүүлэлт болгон авсан байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна.

Шинжээчийн дүгнэлт: 1.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

Үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйд үндэслэн хөтөлбөрийг төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн байна. ШУТИС-ийн ректорын 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/26 тоот тушаалаар 26 хөтөлбөрт CDIO тогтолцоо нэвтрүүлэхээр баталсны нэг нь “Авто инженер” байна.

Хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEOs)-ыг 12 үзүүлэлтээр, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн буюу төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагын жагсаалт(PLOs)-ыг 17 үзүүлэлтээр, мэргэжилтний загварыг 5 үзүүлэлтээр тус тус тодорхойлж, хөтөлбөрийн зорилго ба их сургуулийн эрхэм зорилго хоорондын хамаарлыг гаргажээ.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: “Авто инженер” хөтөлбөрийн зорилго, зорилтыг CDIO Syllabus 2.0-ийн 1-р түвшний сургалтын үр дүнгүүд оновчтой холбон тодорхойлсон.

Ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулж хэвшсэн, ажил олгогч, үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийн дунд хэлэлцүүлэг явуулж, эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа авч хэвшсэн.

MNS ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор хөтөлбөрт хамааралтай оролцогч талуудыг хамруулсан санал асуулгын судалгааг хичээлийн жил бүрийн төгсгөлд авч хэвшсэн.

“Авто инженер” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Тээврийн салбар нь томоохон кампаниудтай хамтран Трансвест Монголиа ХХК-ийн нэрэмжит “Автомашин судлалын лаборатори”, Сейф трек ХХК-ийн нэрэмжит “Семинарын өрөө”, Камминс Монголиа Инвестмент ХХК-ийн нэрэмжит “Дотоод шаталтын хөдөлгүүрийн лаборатори”, Ланд бридж ХХК-ийн нэрэмжит “хичээлийн танхим” зэргийг үе шаттайгаар тохижуулан сургалтад ашиглаж байна.

Сул тал: “Авто инженер” хөтөлбөрийн зорилго нь слесарийн, ашиглалтын, механикийн, зохион бүтээх гэсэн техникийн шинжлэх ухааны 4 үндсэн суурь түвшинг агуулж буйг анхаарах.

Шинжээчийн дүгнэлт: 1.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

“Авто инженер” хөтөлбөрийг бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, үр дүнд суурилсан CDIO хөтөлбөрт тавигдах стандартын дагуу боловсруулж, хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хороогоор хэлэлцүүлэн 2016 онд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлөөр сайшаагдан Ректорын тушаалаар баталгаажсан байна.

“Авто инженер” хөтөлбөрт заагдсан сургалтын төлөвлөгөө, хичээлээр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, суралцахуйн үр дүнд чиглэсэн арга зүй, үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Сургалтын төлөвлөгөөний матрицыг боловсруулан гаргасан нь суралцагч 4 жилийн хугацаанд хэдэн тооны ямар агуулгатай, хэдэн хичээл үзэж судалдаг, сургалт үйлдвэрлэлийн дадлагыг ямар хугацаатай хаана хийдэг зэргийг тодорхой тусгасан бөгөөд хөтөлбөрийн зорилго, зорилттой холбоотой нотлох баримтуудыг бүрэн тодорхойлж гаргасан байна. Мөн түүнчлэн батлагдсан хичээлийн хөтөлбөрүүдийг тусад нь нотлох баримтаар үзүүлсэн болно.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Суралцагчийг инженер, техникийн цөм мэдлэгтэй, гурван төрлийн цогц ур чадвартай мэргэжилтэн болгон хөгжүүлэхэд “Авто инженер” хөтөлбөрөөр эзэмших шаардлагатай дээр дурдсан мэдлэг, ур чадварыг хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтуудтай уялдуулан тэдгээрийн хоорондын холбоог тодорхойлсон матрицыг боловсруулан байна.

Сул тал: Хөтөлбөрийн бичиг баримт агуулгын бүрдэл талаасаа стандарт шаардлагад нийцэж байгаа хэдий ч зарим бүлгүүд хэтэрхий хураангуй байгааг анхаарах.

Оролцогч талуудын санал зөвлөмжийг тусгасан сайн тал байгаа боловч оролцогчийн тоо бага байгааг анхаарах.

Шинжээчийн дүгнэлт: 1.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 1-А. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо нөхцөл байдлын STEEP шинжилгээ хийсэн. Хөтөлбөрт үр дүнд суурилсан сургалтын арга болох CDIO загварыг ашигласан. “Авто инженер” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хичээлээр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, суралцахуйн үр дүнд чиглэсэн арга зүй, үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг.

Дүгнэлт: “Авто инженер хөтөлбөрийн төлөвлөлт” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Авто машины хөгжлийн 4 дүгээр үеийн техникийн онцлог, зарчимд үнэлгээ хийж хөтөлбөрийн хөгжлийн бодлогыг тодорхойлох
2. Дугуйт болон гинжит техник, цахилгаан болон хос хөдөлгүүртэй техникийн ашиглалтын онцлогийг харгалзан үзэж мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг хөгжүүлэх асуудалд судалгаа хийх
3. Төгсөгчдийн хөрвөж ажиллах ур чадвар, дадлага олгоход чиглэсэн CDIO-ийн цөм хичээлийн цагийн багтаамжийг нэмэгдүүлэх.
4. Ажил олгогчийн судалгааны асуулгыг дэлгэрүүлэн “Авто инженер” хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтад заагдсан сургалтын зорилго, зорилтууд хоорондын уялдаа, холбооны дагуу үнэлгээ хийлгэх

Шалгуур 1-Б. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

“Үйлдвэрлэлийн автоматжуулалт” хөтөлбөрөөр төгсөгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тухай МТС-ийн захирал Д.Цолмонбаатарын 2015 оны 2-р сарын 29-нд баталсан төлөвлөгөөний дагуу 2015-2016 оны хичээлийн жилд “Үр дүнд суурилсан боловсролын CDIO” арга зүйг нэвтрүүлэх ажлын хүрээний 5.5-д тусгасан байна. Захирлын жилийн эцсийн тайланд хэрэгжилтийг тусгаж, үр дүнг хэлэлцүүлсэн байна.

“Үйлдвэрлэлийн автоматжуулалт” хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг STEEP шинжилгээ хийж, үр дүнг тусгасан байна.

“Үйлдвэрлэлийн автоматжуулалт” хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, шаардлагын талаарх санал асуулгыг 12 аж ахуйн нэгж, багш нараас санал асуулга авч хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан (2017 он), “Олон улсын инженерийн боловсролын шинэчлэл - CDIO системийг ШУТИС-д нэвтрүүлэх эхний шат”-ны ажлын тайланд (МехТС 2018 он) тодорхой оруулсан байна.

Хөтөлбөрийг гадаад орны тэргүүлэх их сургуулиуд болон Инженерийн боловсролын CDIO стандартуудыг тусган сайжруулсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Уг хөтөлбөр нь манай оронд дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд CDIO стандартыг анх хэрэгжүүлсэн анхны 3 хөтөлбөрийн нэг бөгөөд гадны томоохон сургуулиудын хөтөлбөрийг харьцуулан оруулсан байна.

Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тасралтгүй сайжруулах талаар үе шаттай арга хэмжээ авсан бөгөөд энэ нь хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд жил бүр бичсэн байна.

Сул тал: Хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа салбар болон хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлж байгаа боловч нэгдсэн байдлаар батлагдах нь урт хугацаа шаарддаг байна.

Дүгнэлт: 1.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн зорилго, зорилт нь үр дүнд суурилсан сургалтын CDIO арга зүйг ашигласан бөгөөд дээр өгүүлсэн оролцогч талуудаас авсан судалгааны хүрээнд мэргэжилтэнд олгох үр чадварыг тодорхойлоход чиглэгдсэн байна.

Хөтөлбөрийнхөө зорилго, зорилт, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд 2015 оноос жил бүр ажил олгогч, профессор багш нарын хамтарсан семинар, хамтарсан хэлэлцүүлгүүдийг зохин байгуулж байсан байна.

Жил бүх хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан бичиж хэлэлцүүлдэг байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлохын тулд оролцогч талуудтай хамтран ажиллаж, судалгаа авсан үр дүнг хэлэлцүүлэн оруулсан. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан бичиж хэлэлцүүлдэг нь сайн байна.

Сул тал: Хөтөлбөрийн зорилго, зорилтыг улс эх орны хөгжлийн төлөвлөгөө, хэтийн зорилттой нийцсэн талаар тодорхой тусгаагүй байна. Үүнд: Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, засгийн газрын зорилтот хөтөлбөрүүд гэх мэт

Дүгнэлт: 1.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, үр чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

“Үйлдвэрлэлийн автоматжуулалт” хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийн А-174 тоот тушаалын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан.

Хөтөлбөрөөр суралцагчдын эзэмших мэдлэг, үр чадварыг үр дүнд суурилсан сургалтын CDIO (syllabus 2.0)-г ашиглан өөрийн орны нөхцөл байдал, хөтөлбөрийн оролцогч талуудын саналыг тусган олон удаа хэлэлцүүлэг хийж, боловсруулсан байна.

Хөтөлбөрөөр суралцагчдын эзэмших мэдлэг, үр чадварыг хичээл тус бүрийн агуулгатай холбон сургалтын төлөвлөгөөний матриц гаргасан.

Хөтөлбөрийн үйл ажиллагаа болон суралцагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадваруудыг үнэлэхдээ үнэлгээний олон талт аргуудыг хэрэглэдэг. Үүнд: Хичээлийн үнэлгээний тайланг цөм хичээл тус бүрээр бичдэг, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг жил бүр бичиж тайланг хэлэлцүүлдэг байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө болон хичээлээр олгох ур чадварын хамаарлыг сайн тодорхойлсон бөгөөд байнга сайжруулсан байна. Хөтөлбөр болон цөм хичээлийн өөрийн үнэлгээний тайланг жил бүр бичиж хэлэлцүүлдэг байна.

Дүгнэлт: 1.3 шалгуурыг *бүрэн хангасан* байна.

ШАЛГУУР 1-Б. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагын талаар маш сайн судалгаа хийсэн бөгөөд жил бүр түүнийгээ сайжруулах талаар судалгаа хийж түүнийгээ хөтөлбөртөө тусгасан байна.

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлон ШУТИС болон Механик тээврийн сургуулийн зорилго, зорилттой хэрхэн хамаарч байгаа талаар тусгасан бөгөөд түүнийгээ жил бүр хэлэлцэн сайжруулж иржээ.

Сургалтын төлөвлөгөө, мэргэжилтний ур чадваруудыг байнга сайжруулж боловсруулдаг бөгөөд хичээл болон хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан боловсруулдаг.

Дүгнэлт: “Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн төлөвлөлт” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын зорилтот хөтөлбөрүүдтэй уялдуулах
2. Төгсөгчдөөс судалгаа авахдаа хамгийн багадаа 2-3 жил ажиллаж, мэргэжлийн шаардлага, чадамжийг сайн ойлгосон төгсөгчдийг түлхүү хамруулах
3. Хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөллийг оролцуулах

Шалгуур 1-В. МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

Ажил олгогч, төгсөгчдөөс жил бүр санал асуулга авч, үйл ажиллагаандаа тусган ажилладаг.

Тухайн хичээлийн жилд зохион байгуулагддаг профессорын семинараар оролцогч талуудыг оролцуулсан хөтөлбөртэй холбоотой уулзалт, семинарыг зохион байгуулдаг. Тухайлбал 2019-2020 оны намрын улиралд профессорын семинар нийт 15 удаа зохион байгуулагдсан.

Гадаадын ижил төстэй сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийгдсэн.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагатай холбоотой санал асуулгын дүнд үндэслэн дадлагын цагийг нэмэгдүүлэх, CDIO цөм хичээлүүдийг заах зэрэг идэвхтэй сургалтын аргуудыг нэвтрүүлэн, хөтөлбөрийг сайжруулах ажлууд хийгдэж ирсэн байна.

Сул тал: Өөрийн үнэлгээний тайланд Металл боловсруулах технологи, Машин үйлдвэрлэлийн технологи гэсэн 2 нэршил хэрэглэж байгаа нь ойлгомжгүй.

Дүгнэлт: 1.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

Импортоор орж ирж буй металл бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн судалгааг 2014-2018 оноор гарган, харуулсан байна.

Салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ хийгдсэн.

STEER болон PDCA шинжилгээ хийгдсэн. Мэргэжилтний загварыг гаргасан.

Хөтөлбөрийн зорилтууд болон CDIO-ний сургалтын үр дүнгүүдтэй хэрхэн холбогдож буйг харуулсан.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн шинжилгээг олон аргаар хийж, харьцуулсан. Сэлбэг хэрэгсэл, бэлдцийг жил бүр гаднаас импортоор оруулдагтай холбоотойгоор тодорхой хэсгийг нь Монголдоо үйлдвэрлэх, энэ чиглэлийн үйлдвэрүүдийг дэмжиж хөгжүүлэх шаардлагатай уялдаатайгаар тухайн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ шаардлага их байгааг харуулсан.

Дүгнэлт: 1.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

2014 оноос шинэчлэн батлагдсан хөтөлбөрт дадлагын цагийг нэмэгдүүлж, бүтээлч байдал, сурсан мэдсэнээ ашиглахад суралцах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд зорилгоор инженерийн удиртгал зэрэг хичээлүүд нэмэгдсэн.

Хөтөлбөрт орж буй хичээлүүд болон ур чадварын матрицыг гаргасан.

Шинжээчийн үнэлгээ:

Сул тал: Өөрийн үнэлгээний тайлангаас үзэхэд дадлагын цаг нэмэгдсэнтэй холбоотойгоор хүндрэл бий болж байгаа талаар дурдагдсан байсан бөгөөд тодруулахад энэ нь үйлдвэр компаниудтай ойр ажиллах, оюутнуудад мэргэжлийн ур чадвар эзэмших зэрэгт давуу талыг олгож буй боловч багшийн ачаалал нэмэгдэж, үнэлгээ бага байгааг хэлж байсан.

Ажил олгогчидтой уулзах үеэр ч практик дадлага, туршлага олгоход илүү анхаарч ажиллах шаардлага байгааг онцолж байв. Тиймээс дадлагын цагийг нэмэгдүүлж, багшид ирэх ачааллыг хэрхэн үнэлэх талаар холбогдох журамд тодорхой өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.

Дүгнэлт: 1.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 1-В. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Олон улсын түвшинд хөтөлбөрийг боловсруулахдаа мэргэжлийн хүрээ болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг эхэлж гаргадаг бөгөөд PDCA шинжилгээнд энэ хөтөлбөрт суралцсанаар ямар чадваруудыг (нийт 7) эзэмшихийг оруулсан байна. Мөн хөтөлбөрийн зорилго, зорилтууд эдгээрийн CDIO-ийн суралцахуйн үр дүнгүүдтэй хэрхэн холбогдох, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар болон сургалтын зорилго, зорилт хоорондын уялдаа, сургалтын төлөвлөгөөний матриц, хичээл хоорондын холбоос, залгамж холбоо, түүнд хийсэн SWOT шинжилгээ зэрэг олон талаас нь шинжилж харуулсан байна.

Хөтөлбөрүүдийн хувьд нийтлэг ажиглагдаж буй зүйл нь хөтөлбөр болон хичээлтэй холбоотой мэдээллүүд нээлттэй биш, зөвхөн удирдлагын мэдээллийн систем рүү орж харах боломжтой, оюутнуудад зориулсан хөтөлбөрийн гарын авлага (хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл, хичээл бүрийн тодорхойлолтыг оруулсан – module handbook) гаргадаггүй нь тухайн суралцагчид бүх мэдээллийг нэгтгээд үзэхэд хүндрэлтэй байгааг цаашид анхаарах шаардлагатай. Мөн мэдээллийн системд зарим нэг хичээлийн (үйлдвэрлэлийн дадлага) мэдээлэл ороогүй эсвэл мэдээлэл дутуу байсан.

Дадлагын цагийг нэмэгдүүлж, инженерийн удиртгал зэрэг хичээлүүдийг оруулсан боловч ажил олгогчдын зүгээс суралцагчдын төлөвшил, хандлагыг өөрчлөхөд анхаарах шаардлагатай талаар яригдсан. Энэ нь гэр бүл, бага, дунд сургуулиас эхлээд боловсролын тогтолцооны шинэчлэлтэй холбоотой асуудал боловч хөтөлбөр хариуцагч талуудын хувьд зайлшгүй анхаарч, бусад сургуулиудад хэрэгжиж буй сайн туршлагаудаас суралцах нь зүйтэй. Мөн мэргэжил сурталчлах, мэргэжлийг онцлогийг ойлгуулахтай холбоотойгоор элсэгчид болон ажил олгогчдыг оролцуулсан, сургалтын орчин, мөрдөгдөж буй дүрэм журам танилцуулах, хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх зорилго бүхий чиг баримжаа олгох арга хэмжээг хичээлийн жилийн эхэнд тогтмол зохион байгуулах нь илүү үр өгөөжтэй болно.

Тус сургуулийн хувьд сүүлийн жилүүдэд АХБ, Жайка зэрэг байгууллагын санхүүжилтээр сургалтын орчинг сайжруулахтай холбоотой хөрөнгө оруулалт хийгдсэний дотор металл хийц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжүүд ирсэн нь цаашид үйлдвэртэй хамтарсан судалгаа хийх өргөн боломжийг олгож байна.

Дүгнэлт: “Металл боловсруулах технологи хөтөлбөрийн төлөвлөлт” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн нэр, индексийг тодорхой болгох
2. Мэргэжил сурталчлах, мэргэжлийн онцлог, ирээдүйн төлвийг ойлгуулах, мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах
3. 2018 оноос хойш төгсөгчдийн ажлын байрны судалгаа, төгсөгчдийн ур чадаврын судалгааг хийх

Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

Бакалаврын сургалтын хөтөлбөр (баримт бичиг, 2014.06.14-нд ХХ-оор хэлэлцүүлсэн), Сургалтын төлөвлөгөө (ШУТИС-ийн эрдмийн зөвлөл, 2014.07.02), Модуль хичээлийн уялдаа холбоо, хөтөлбөрийн мод, Хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц, Үйлдвэрлэлийн дадлагын гэрээ зэрэгт суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тойдорхойлсон.

Энэ талаар багш, суралцагчидтай хийсэн ярилцлага, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангаас тодорхой мэдээлэл өгсөн.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн эрхэм зорилгыг ШУТИС-ийн эрхэм зорилгод нийцүүлэн боловсруулж, ямар үүрэгтэй оролцохыг тодорхойлсон байдаг.

Хөтөлбөрийг 3.5 жилээс 4 жилд багтаан суралцах боломжтой, 9 кредитийн үйлдвэрлэлийн дадлага, 5 кредитийн дипломын төсөл, мэргэжлийн хичээлийн 58 кредитээс ≈15 кредит нь төсөл, лаборатори, практикийн хичээл эзэлж байгаа нь дадлага, туршилтын ур чадварыг хөгжүүлэх, суралцагчдад хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг эзэмшүүлэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүд хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй хэрхэн холбоотой байгааг матрицаар тодорхой гаргаж, модуль хичээлийн залгамж холбоог хангаж байна.

Сул тал: Металл боловсруулах технологи хөтөлбөрийн нэртэй боловч баримт бичгийн бүрдүүлэлтэд машин үйлдвэрлэлийн технологи чиглэлээр мэргэжлийн хичээлүүдийг төлөвлөсөн байгаа нь өөр хоорондоо зөрчилдөж байна.

Хөтөлбөр хариуцсан профессор багш нар хөтөлбөрийн сайжруулалтыг тасралтгүй хийж, холбогдох асуудлыг сургуулийн хөтөлбөрийн хороонд шийдвэрлүүлэхээр уламжилдаг боловч шийдвэрлэхэд хугацаа их зарцуулдаг, гаргасан шийдвэр, хэлэлцсэн асуудлын талаар мэдээлэл өгдөггүй, хөтөлбөр батлагдахгүй уддаг зэрэг асуудлууд гардаг. Энэ нь хөтөлбөрийн сайжруулалтыг хийхэд ихээхэн хүндрэлтэй, батлагдаагүй хөтөлбөрөөр сургалт явуулахад хүргэх асуудлыг үүсгэдэг байна.

Ажил олгогч болон төгсөгчдийн зүгээс үйлдвэрлэлийн дадлагын цагийг харьцангуй бага, 7 ба 8-р улиралд буюу нэлээд хожуу судалж байгаа нь ажил мэргэжлийн чиг баримжаа олох, дадлагажих, хэтийн мэргэжлээ сонгоход хязгаарлалт үүсгэж байгаа тал ажиглагдаж байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн танхимд болон бие даан суралцах цагийн ачааллыг сургалтын журмын дагуу бодож гаргасан боловч хичээлээр өгч буй даалгавар нь энэхүү төлөвлөсөн ачаалалд нийцэж байгаа эсэхийг судалдаггүй.

Оюутан хэдийгээр багшаа сонгон судалдаг боловч улирлын дунд буюу сургалтын явцад багш солигдох үзэгдэл гарсаар байна. Мөн анги дүүргэлтээс хамаарч багш сонгох боломж хязгаарлагдмал байдаг. Ихэнх мэргэжлийн хичээлийг нэг багш ордог нь оюутны сонгох боломжийг бууруулах талтай.

Дүгнэлт: 2.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн болон бусад 2 хөтөлбөрийн цөм хичээлийг үр дүнд суурилсан сургалтын арга зүйг хэрэгжүүлж байна.

Суралцахуйн болон багшлахуйн арга зүйг хэрэгжүүлэхдээ Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд боловсруулан гаргасан арга зүйн зөвлөмжийг удирдамж болгон хэрэглэдэг.

Ярилцлага, судалгаанаас сургалтын явцад суралцагчдын багаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд түлхүү анхаардаг болох нь ажиглагдлаа.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хичээлийн хөтөлбөрт сургалтын төрөл бүрийн арга зүй (асуудалд суурилсан, туршилтад суурилсан, бодит байдалд суурилсан сургалт, симуляци)-г хэрэглэж, бие даан, чацуутны, багийн сургалтыг амжилттай явуулж байна.

“Үйлдвэрлэлийн автоматжуулалт” хөтөлбөрийн хувьд багшийн заасан хичээлийн арга зүйн талаар санал асуулгын судалгаанд суралцагчид “санал нийлж байна” гэсэн үнэлгээ өгчээ.

“Авто инженер” хөтөлбөрийн зарим багш нар сургалтын явцад Google Classroom-ийг ашиглан суралцагчидтай харилцах, зөвлөгөө өгөх, даалгавар өгөх, хүлээн авах зэргээр идэвхтэй ашигладаг байна.

Сул тал: Хэдийгээр үр дүнд суурилсан, идэвхтэй сургалтын арга зүйг хичээлдээ хэрэглэж буй багш байгаа хэдий ч уламжлалт хэлбэрээр сургалтыг зохион байгуулж байгаа тохиолдол нэлээд байна. Үүнтэй холбоотой үр дүнд суурилсан сургалтын арга зүй нь багшаас нөр их цаг, хүч хөдөлмөр шаардагддаг, бусад багш нартай адил үнэлгээтэй байдаг.

Англи хэлний хичээл ордог боловч мэргэжлийн түвшинд англи хэлний ярианы чадвартай болж төгсөж чадахгүй байна.

Зарим төгсөгчдөд ажлын байран дээр гарахад онолын мэдлэгийн түвшин хангалттай боловч үйлдвэрийн болон лабораторийн багаж, тоног төхөөрөмжтэй ажиллахад хүндрэл учирдаг байна.

Төгсөгч, ажил олгогчидтой хийсэн ярилцлагаас 1) сургалтын арга зүйг багшаас мэдээлэл авах, хэлснийг хийхээс илүүтэй төгсөгч өөрсдөө санаачилгатай, хувийн болон хамтын хариуцлагатай болгох талаас нь сургалтын арга зүйг сайжруулах. 2) сургалтын үйл ажиллагааны явцад багш нар оюутан бүрт ижил даалгавар өгөхөөс гадна суралцагч бүрийн ялгаатай сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд анхаарах, 3) ёс зүйн асуудлуудыг сургалтад тусгаж оруулах, тухайлбал ном зүй, бусад эх сурвалжийг зүй зохистой хэрэглэх, ашиглах чадвар суулгах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Дүгнэлт: 2.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

Тухайн хичээлийн онцлогоос хамаарч хичээлээр олгох мэдлэг, чадвар, дадлын түвшин өөр өөр байдаг учраас 70 онооны задаргааг хичээл тус бүр дээр гаргаж баталгаажуулсан байна.

Оюутны тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэх ёстой хичээлийн үнэлгээний 100 онооны 10-15 оноог ирцэд өгдөг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Суралцагчдад бие даалтын цаг маш үр өгөөжтэй байдаг. Хичээл бүрээр бие даалтын цаг (7 хоногт 2 цаг)-ийг хичээлийн хуваарьт тусган оюутны суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг нь хөтөлбөрийн үр дүнд эергээр нөлөөлж байна.

Оюутны бодит гүйцэтгэлийг үнэлэх олон арга (тест, тайлан хамгаалах, бүтээл хийлгэх, илтгэл тавих гэх мэт)-ыг хэрэглэж байна.

“Автоинженер” хөтөлбөрийн хувьд Plickers аппликейшн ашиглан суралцагчийн мэдлэг, ур чадварыг үнэлж байна.

Сул тал: Суралцагчийн тухайн улирлын голч дүнгээр сурлагын амжилтыг гаргадаг боловч хичээлд унасан оюутны тоо, чанар, амжилт зэргийн судалгааг хийдэггүй учраас оюутны ахиц дэвшлийг үнэлэхэд төвөгтэй. Үүнтэй холбоотой ажил олгогчдын зүгээс оюутныг бодитой үнэлэх, амжилттай судалж чадахгүй бол журмын дагуу сургуулиас хасдаг байх

зэрэг саналыг дэвшүүлж байна. Өөрөөр хэлбэл ажил олгогчид төгсөгчдийг ажлын байран дээр дадлагажуулах, бэлтгэх, багаар ажиллах, хариуцлага хүлээх, цаг баримталж сурах зэрэгт маш их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулж байгааг суралцагчийг бодитой үнэлэхгүй байгаатай холбон тайлбарлаж байна.

“Автоинженер” хөтөлбөрийн хувьд дахин судалж байгаа, амжилтгүй судалсан оюутны тоог гаргасан боловч учир шалтгааныг илрүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар тайландаа дурдаж оруулаагүй байна.

Дүгнэлт: 2.3 шалгуурыг *бүрэн хангасан* байна.

ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ :

Хөтөлбөрийн зорилго нь сургуулийн эрхэм зорилгод нийцсэн бөгөөд үр дүнд суурилсан сургалтын арга зүйг сургалтын үйл ажиллагаандаа тусган оруулж, арга зүйг тасралтгүй хөгжүүлж, багш нар энэ чиглэлийн сургалтад тасралтгүй хамрагддаг байна.

Сургалтын хөтөлбөр нь суралцагчийн цогц чадамжийг эзэмшүүлэхэд чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, агуулгын давхардалгүй боловсруулагдсан.

Сургалтын арга зүй оновчтой эсэхийг голч дүн, хичээлийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн үнэлж, ажил олгогчдын саналыг тусган сургалтын хөтөлбөрт сайжруулалт хийдэг боловч хөтөлбөрийн хороогоор батлуулах үйл ажиллагаа сааталтай байдаг.

Хичээлүүдэд ирцийн 10-15 хүртэлх оноог оюутанд өгдөг нь оюутны эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх зорилттой нийцэхгүй байгаа тул оюутны үнэлэх журмыг эргэн харах шаардлагатайг илтгэж байна.

Төгсөгчдөд англи хэлний ярианы чадвар шаарддагтай холбоотой англи хэлний заах арга зүй, агуулгыг сайжруулан боловсруулах, суралцахуйн үр дүнд нийцсэн сургалтыг явуулах шаардлагатай байна.

Дүгнэлт: “Сургалтын үйл ажиллагаа” шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** байна.

Зөвлөмж:

1. Сургуулийн хөтөлбөрийн ерөнхий, бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхимийн хөтөлбөрийн дэд хороодын үйл ажиллагааг уялдуулж, мэдээллийг цаг тухайд нь, шуурхай хүргэх, шийдвэрлэх
2. CDIO сургалтад бүх багш нарыг жигд хамруулж, өөрсдийн заадаг хичээлүүддээ идэвхтэй сургалтын арга, үр дүнд суурилсан сургалтын арга барилыг нэвтрүүлж, харилцан суралцаж, туршлага солилцох
3. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн хичээлийн багшийг сонгох боломжийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Энэ нь хичээлийн агуулга, заах арга зүй, үнэлгээ, сургалтын материалыг багш нар хамтран бэлтгэх, харилцан суралцах, туршлага солилцох, суралцахуйн үйл явцыг чанаржуулахад үнэтэй хувь нэмэр оруулна.

Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

“Авто инженер”, “Үйлдвэрлэлийн автоматжуулалт”, “Металл боловсруулах технологи” ШУТИС-ийн хичээлийн (Механик, Тээврийн сургууль) 7-р байранд төвлөрүүлэн сургалт, судалгааны ажил үйлчилгээ үзүүлж байна.

Механик, Тээврийн сургуулийн Тээврийн салбар нь 2291.47 м2 ашигтай талбай бүхий байранд сургалт, судалгааны ажил үйлчилгээ үзүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд 12 танхим, семинарын зориулалттай 6 танхим, лабораторийн зориулалттай 11 танхим, оюутны бие даалтын өрөө, номын сан зэрэг оюутны үйлчилгээнд зориулан 5 газрыг ашиглаж байна.

Механик, Мехатроникийн Салбар нь 2147,3 м2 ашигтай талбай бүхий байранд сургалт, судалгааны ажил үйлчилгээ үзүүлж байна. Мэргэжлийн багш, оюутнууд хичээлийн байранд сургалтын зориулалтаар багш нарын 6 өрөө, лекц, семинарын танхим 5, сургалтын зориулалттай лаборатори 5, CDIО урлан 2, номын сангийн салбар байрладаг.

Машин үйлдвэрлэлийн салбар нь 2147,3 м2 ашигтай талбай бүхий байранд сургалт, судалгааны ажил үйлчилгээ үзүүлж байна. Багш нарын 5 өрөө, лекц, семинарын танхим 10, сургалтын зориулалттай лаборатори, урлан 10, номын сангийн салбар байрладаг.

Шинжээчийн үнэлгээ:

Анги танхим, сургалтын тоног төхөөрөмж, сургуулийн дотоод орчны өнгө үзэмж зэргийг үе шаттайгаар тохижуулан жил бүр урсгал, их засваруудыг байнга хийж ирсэн байна.

Лаборатори, анги танхим, өрөө тасалгаа болон түүнд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж нь боловсролын байгууллагад тавигдаж буй эрүүл ахуйн стандартын шаардлага, хөдөлмөрийн хуульд заасан хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллахад бүрэн хангаж байна.

Давуу тал: Сургалт судалгааны ажил явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчинг сайжруулахад төгсөгчид, болон салбарын тэргүүлэх пүүс компани оролцоог чадварлаг ашиглаж байна.

Сул тал: ШУТИС-ийн хичээлийн (Механик, Тээврийн сургууль) 7-р байрны өмнө баригдаж байгаа орон сууцны барилга оюутан суралцагчдын орж гарах хөдөлгөөнд саад болох аюулгүй орчинд сурах эрх зөрчигдөх эрсдэл бий болж байна. (Механик, Тээврийн сургууль) 7-р байрны ашиглалтын хугацаа дуусаж байна.

Дүгнэлт: 3.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

“Авто инженер”, “Үйлдвэрлэлийн автоматжуулалт”, “Металл боловсруулах технологи” хэрэгжүүлэхэд зориулж тус сургуулийн эрдэмтэн багш судлаач нар мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн агуулгад 24 төрлийн 16 төрлийн программ хангамжийг ашиглаж байгаагаас 9 программ хангамжийг албан ёсны лицензтэй Autodesk Fusion 360, Classroom management software, 3D stylus touch, Solidworks, “MTS simulator”, CAD/CAM/CAE системийн программ, Nanjing swansoft simulator, CNC simulator, Mastercam 2018 программуудыг виртуал лаборатори хэлбэрээр ашиглаж байна.

2017-2018 оны хичээлийн жилд Сургалтын хөтөлбөрт багтсан 21 хичээлийн дадлагын хичээлд нийт 51 нэр төрлийн 5,7 сая, 2018-2019 оны хичээлийн жилд нийт 26 нэр төрлийн 3,7 сая төгрөгний лабораторийн хэрэглэгдэхүүн авч сургалтад зарцуулжээ.

Дээд боловсролын шинэчлэлийн төсийн хүрээнд 3 багцаар 50 төрлийн 1100 орчин туршилт, дадлага гүйцэтгэх тоног төхөөрөмж авч сургалтад ашигласан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг үндсэн лаборатори, урлангуудад мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн лабораторийн ажил, дадлагын ажлыг оюутны бие даалтын ажил, дипломын төгсөлтийн ажлын туршилт судалгааны боловсруулалтыг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон.

Лабораторийн шинэчлэлийг гадны хөрөнгө оруулалтыг хийсэн сайхан туршлага байна.

Сул тал: Сандал ширээ мебель хэрэгсэл хуучирсан.

Дүгнэлт: 3.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан болон Механик, Тээврийн сургуулийн номын сангийн уншлагын танхим, Эрдэм шинжилгээний тэнхим, гэрээр ном олгох фонд гэсэн нэгжээр номын сангийн үйлчилгээ үзүүлж байна.

Механик, Тээврийн сургуулийн номын сан нь 714 м 2 талбайтай, дохиолол, хамгаалалт бүхий 248 суудалтай чөлөөт уншлагын танхим, 140 м 2 талбайтай фонд болон эрдэм шинжилгээний уншлагын танхим, утасгүй интернэтийн (wireless) орчинтой.

Номын сан нь нийт 30008 гаруй ном хэвлэл, сурах бичиг, гарын авлага, тогтмол хэвлэлээр багш, оюутанд номын сангийн үйлчилгээг үзүүлж байна. Номын сангийн хөмрөгийн 50% монгол, 40% орос, 8% англи, 2% нь бусад хэл дээр байгаагаас 40 гаруй хувь нь мэргэжлийн ном сурах бичиг байна.

Багш бүр өөрийн заадаг хичээлүүдийн лекц, семинар, бие даалтын материалуудыг стандартын дагуу бэлтгэж, хичээлийн файлын бүрдүүлэлт хийж, шинэ мэдээллээр баяжуулдаг. Хөтөлбөрийн хэмжээнд мэдээллийн технологийн ололт амжилтыг сургалтад нэвтрүүлэхэд анхаарч, E-сургалтыг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилгоор мэргэжлийн бүх хичээлүүдийн лекцийг Power point программ дээр бэлтгэн заадаг нь хичээлүүдийг зайн ба цахим сургалтад ашиглах үндэс болж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: E-сургалтыг явуулж байгаа багш нарын туршлага нь оюутнуудад үзүүлэх үйлчилгээг хэрэглэгчид нь ойртуулсан сайн арга хэмжээ болжээ.

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном, сурах бичиг, мэдээллийн эх үүсвэртэй. ШУТИС-ийн Төв номын санд хуримтлагдсан сан, хөмрөгийг ашиглах боломжтой, тэр нь хүртээмжтэй.

Сул тал: “Машин үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийн мэргэжлийн хичээлд үндсэн сурах бичиг хангалтгүй. Хичээлийн өдрүүднд, ажлын цагаар ачаалал ихсэж, интернетийн хурд удааширдаг.

Дүгнэлт: 3.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

МТС-ийн байранд багш нарын 10 өрөө, сургалтын зориулалтаар лекц, семинарын танхим 10, лаборатори ба урлан 18, номын сан 2 байна. Кабинет, сургалтын тоног төхөөрөмж, сургуулийн дотоод орчны өнгө үзэмж зэргийг үе шаттайгаар тохижуулан жил бүр урсгал болон их засваруудыг байнга хийж ирсэн. Лаборатори, анги танхим, өрөө тасалгаа болон түүнд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж нь боловсролын байгууллагад тавигдаж буй эрүүл ахуйн стандартын шаардлага, хөдөлмөрийн хуулинд заасан хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах шаардлагад бүрэн нийцэж байна. Тус 3 хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээлийн агуулгад мэргэжлийн 8 программ хангамжийг хэрэглэж байгаагаас албан ёсны лицензтэй “MTC Simulator”, “CAD” программууд байна. Энэ нь цаашид мэргэжлийн программ хангамжийн хүртээмжийг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт: “Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Багш нар хичээлийн агуулгыг шинэчлэн, шинэ багаж төхөөрөмжийг сургалтад нэвтрүүлж байгаа шинэчлэлтэй холбоотойгоор шинээр сурах бичиг, гарын авлага, бүтээл туурвих
2. Механик, тээврийн сургуулийн багш нарын бүтээлийг хэвлэх эрдэм шинжилгээ судалгааны сэтгүүлтэй болох
3. Худалдан авалтаар мэргэжлийн хичээлийн хүрээнд судлах ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх
4. Мэргэжлийн хичээл бүр дээр виртуал орчин, бодит байдалд ойртсон зохиомж, бодлогууд, даалгавруудыг дууриалган үзүүлэх, бодиторр харуулах боломжтой сургалтын материалыг E контентын түвшинд боловсруулах ажлыг эрчимжүүлэх

Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

1999 оноос кредит системийг хэрэгжүүлж эхэлснээс гадна оюутны хувьд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдээс болон багшаа сонгох боломжийг бүрдүүлсэн.

UNIMIS v.1.0 (University Management Information System) удирдлагын мэдээллийн системийг 2003 оноос хөгжүүлэн ажиллуулж байгаа бөгөөд энэ систем нь “Сургалтын процессын удирдлага”, “Эрдэм шинжилгээ, технологи, инновац”, “Санхүү”, “ Хүний нөөц”, “Дижитал номын сан” зэрэг дэд хэсгүүдээс бүрддэг. ШУТИС 2014 оноос “University Cloud” системд шилжсэн.

Хөтөлбөрийн удирдлагатай холбоотой эрхзүйн зохицуулалт нь ШУТИС-ийн дүрэм болон бусад журмуудаар хийгддэг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: ШУТИС-ийн хувьд салбар нь хөтөлбөрүүдийг эрхлэн хэрэгжүүлдэг бөгөөд 2003 оноос сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, хэрэгжүүлж ирсэн туршлагатай, үйл ажиллагаа нь бүрэн жигдэрсэн.

Дүгнэлт: 4.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

Тус сургуулиас хариуцан “CAD-CAM”-ийн олимпиад , Монгол Инженер арга хэмжээг жил зохион байгуулдаг.

Машин үйлдвэрлэлийн салбарын профессорын семинарыг тогтмол зохион байгуулж,

сургалт, судалгаатай холбоотой илтгэл, асуудлуудыг хэлэлцдэг.

МехТС нь ОХУ болон БНХАУ-ын зарим их сургуультай хамтран ажиллаж, солилцооны хөтөлбөрт оюутан явуулдаг.

Эрдэнэт үйлдвэр, Мон-Шибасаки, Дархан Геомаш зэрэг компаниудтай хамтран ажиллаж, оюутнуудыг дадлагад хамруулдаг.

Зам тээврийн яамтай хамтран зөвлөх инженерийн зэрэг олгох, сунгах сургалтуудыг хариуцан зохион байгуулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: МехТС нь гадны их сургуулиудтай хамтран ажиллаж, багш, оюутнуудыг солилцоогоор илгээж, мэргэжлийн яам, ТББ-уудтай хамтран төгсөгчдийг давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, стандарт боловсруулах зэргээр нягт хамтран ажилладгаас гадна Монгол инженер, CAD-CAM зэрэг үндэсний хэмжээний арга хэмжээ, олимпиадыг хариуцан зохион байгуулахад оролцдог.

Сул тал: Зөвхөн зөвлөх инженерийн зэрэг олгох, эрх сунгах сургалтаар хязгаарлахгүйгээр төгсөгчид болон компаниуд руу чиглэсэн, тэдэнд хэрэгцээтэй сургалтыг санал болгож, хамтран ажиллах.

Дүгнэлт: 4.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

Сургалтын материаллаг бааз, орчинг сайжруулах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулдаг.

Салбарууд сургалтын төлбөрөөс орох орлогын зохих хувийг мэргэжил дээшлүүлэх, сургалтын орчин, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр захиран зарцуулах эрхтэй.

Олон улсын, үндэсний, сургуулийн уралдаан, тэмцээн, олимпиадад амжилттай оролцсон оюутнуудад кредит тооцох, шагнаж, урамшуулах журмыг мөрддөг.

Сургуулийн хөгжлийн үзүүлэлт, нэг оюутанд ногдох өртөг зардлын тооцоог сүүлийн 3 хичээлийн жилээр тооцож харуулсан.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтөд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага, профессорууд оролцдоггоос гадна сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, багш нарын бичсэн ном сурах бичиг хэвлүүлэх, багш нарын ажиллах нөхцөлийг сайжруулах зэрэгт тодорхой санхүүжилтыг батлуулж, авдаг.

Сул тал: Өөрийн үнэлгээний тайланд сургуулийн хөгжлийн үзүүлэлт, уралдаан тэмцээнийг хэрхэн санхүүжүүлсэн талаар оруулсан боловч сүүлийн 2 жилийн үзүүлэлтүүдийг оруулаагүй байна. Металл боловсруулах хөтөлбөрийн хувьд 2016, 2017 онд зарлага нь орлогоосоо давсан үзүүлэлттэй байгаад ямар дүгнэлт өгч байгаа нь тодорхой бус байна.

Дүгнэлт: 4.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

МехТС нь “CAD-CAM”-ийн олимпиад , “Монгол Инженер” эрдэм шинжилгээний хурал, сургалт, бүтээлийн үзэсгэлэнг жил зохион байгуулдаг.

МехТС-ийн оюутнууд сургууль болон улсаа төлөөлж “Robocon”, “Green Car” зэрэг олон улсын тэмцээнүүдэд амжилттай оролцож, эхний байруудыг эзэлж байсан.

Элсэгчдэд зориулсан “ШУТИС – бидний бахархал” зэрэг мэргэжил сурталчлах өдөрлөг, арга хэмжээнд оролцож, сургууль, хөтөлбөрүүдээ сурталчилдаг.

Идэвхжүүлэлтийн төлөвлөгөө гарган ажилладаг (Авто инженер).

Монгол улсын стандартыг боловсруулахад оролцдог (Авто инженер, нийт 24 стандарт)

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: МехТС-ийн багш, оюутнууд үндэсний хэмжээний олимпиад, тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэнг зохион байгуулахад оролцдоггоос гадна “Robocon”, “Green Car” зэрэг олон улсын тэмцээнүүдэд амжилттай оролцож, улсынхаа нэрийг дуудуулж ирсэн энэ сургуульд сурч оюутнууд, суралцахаар сонирхож буй элсэгчдийн хувьд суралцах идэвхийг өрнүүлэх, идэвхтэй суралцах, мэргэжлээрээ бахархах том хүчин зүйл болдгийг тус сургуульд шинжээчээр очиж ажиллах явцад анзаарагдаж байна.

Сул тал: Сүүлийн жилүүдэд (2018, 2019) олон улсын уралдаан оюутнуудаа оролцуулахад ямар зардал гаргасан нь тайланд тусгагдаагүй байна.

Дүгнэлт: 4.4 шалгуурыг бүрэн хангасан байна.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн болон МТС-ийн веб хуудаснаас уулзалт, семинар, хурал болон бусад үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээ, үйл явдлын мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой. Мөн элсэгчдэд зориулсан болон сургалт, судалгаа, хөтөлбөртэй холбоотой, оюутанд зориулсан зэрэг мэдээллийг тогтмол хүргэдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: МехТС нь өөрийн веб хуудсандаа элсэлт болон хөтөлбөрүүдтэй холбоотой мэдээлэл, танилцуулга, хариуцах нэгжийн тухай дэлгэрэнгүй оруулсан байна.

Сул тал: МехТС-ийн веб хуудасны аль нэг салбарыг сонгоход багшлах бүрэлдэхүүний тухай мэдээлэл нь ороогүй байна.

Дүгнэлт: 4.5 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа нь бүрэн төлөвшсөнөөс гадна гадаад, дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ нь хангалттай түвшинд явагдаж байна.

Төсвийн төлөвлөлт болон зарцуулалтад хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын саналыг авч, оролцуулдагас гадна CDIO зэрэг сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, сургалтын орчныг сайжруулахад тодорхой зардлуудыг тусган ажилладаг.

Олон улсын болон үндэсний уралдаан, тэмцээнүүдэд тус сургуулийн багш, оюутнуудын баг амжилттай оролцож ирсэн болон үндэсний хэмжээний арга хэмжээ, олимпиадыг зохион байгуулахад оролцдог нь МехТС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг олон нийтэл таниулах, элсэгчдийг татахад нөлөөлдөг гэж үзэж байна.

ЕБС-ийг төгсөгчдийн тоо зарим жилүүдэд цөөн байдагтай холбоотойгоор элсэгчдийг идэвхжүүлэх, хөтөлбөрөө сурталчлах ажлуудыг тодорхой төлөвлөгөөтэйгөөр явуулах нь чухал юм. Тухайлбал жил бүр сургуулийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, элсэхээр

сонирхсон хүүхдүүд, эцэг эхчүүдэд хөтөлбөрүүдээ танилцуулж, нээлттэй хичээл, сургалтын орчноо танилцуулах боломжтой.

Дүгнэлт: “Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. ЕБС-ийг төгсөгчдийн тоо зарим жилүүдэд цөөн байдагтай холбоотойгоор элсэгчдийг идэвхжүүлэх, хөтөлбөрөө сурталчлах ажлуудыг тодорхой төлөвлөгөөтэйгөөр явуулах

Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

Оюутан элсүүлэх дүрэм, журам (<https://www.elseit.edu.mn>), бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах (https://www.must.edu.mn/mn/sutgalt_master/) журам нь тогтвортой хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан:д элсэгчдийн ЭЕШ-ын дундаж үзүүлэлт (2015-2019 он)-ийг гаргаж, дүгнэлт хийсэн байна.

Шинэ элсэгчдэд зориулж сургуулийн вэб хуудсаар дамжуулан видео танилцуулга хийж мэдээлэл түгээдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Жил бүр элсэгчдэд зориулсан сурталчилгааг УБ хотын ЕБСургууль болон хөдөө орон нутгаар салбарын багш нарыг хуваарилан мэргэжлийн сурталчилгааг тогтмол явуулж, жил бүр Боловсролын яармаг, боловсролын супермаркетэд оролцож мэргэжлээ сурталчилснаар элсэгчдийн тоог нэмэгдүүлэх арга замыг хайж байна.

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад чиглэсэн ШУТИС-ийн нээлттэй хаалганы өдөр “Ирээдүйн мэргэжилтэн–бидний оролцоо” <https://www.must.edu.mn/mn/content/show/id/8294> сайт тогтмол ажилладаг.

Сул тал: Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж үзүүлэлтээс (2015-2019 он) харахад физик, математик судлагдахууны онооны дундаж буурсан. Элсэлтийн тоо “Үйлдвэрлэлийн автоматжуулалт” хөтөлбөрөөс бусад тохиолдолд харьцангуйгаар багассан байна.

Шинээр элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн мэдээлэл бүхий зөвлөмж, гарын авлага байдаггүй.

Дүгнэлт: 5.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

Суралцагчдад суралцах судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол чанартай үзүүлдэг нь дараах ажлуудаас тодорхой байв. Үүнд: Оюутны клубын оролцогчдын хийсэн бүтээлүүд, шагналууд, Олон улсын тэмцээнд тогтмол оролцож буй байдал, Багш, суралцагчидтай хийсэн асуулга, ярилцлага гэх мэт.

ШУТИС-ийн вэб хуудсанд сургалтын нэгдсэн хуанлиг хичээлийн жил бүрийн эхэнд оруулсан нь оюутан, эцэг эх багш нар тухайн хичээлийн жилийн туршид сургалттай холбоотой мэдээллүүдийг авах боломжтой болсон.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Суралцагчдад ирээдүйн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр “Job Fair” үйл ажиллагааг ШУТИС-ийн хэмжээнд жилд 2 удаа тогтмол зохион байгуулдаг. Суралцагчдын суралцах, судлах арга зүйд зөвлөх багш, судалгааны удирдагч багш, хичээл ордог багш нар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг, оюутнууд үүнд сэтгэл ханамжтай байна.

Сул тал: Хэдийгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг боловч оюутнууд энэ чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулах, бодит амьдралтай нийцүүлэх хүсэлтийг өгсөөр байгаа нь энэ үйл ажиллагааг явуулж буй агуулга, хэлбэрийг өөрчилж, хүртээлтэй болгох шаардлага байсаар байгааг харуулж байна. Мөн энэ чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж буй талаар мэдээллийн хүртээмж харьцангуй сул байна. Үүнтэй холбоотой инженерийн удиртгал хичээлийн агуулга, арга зүйг оюутны сэтгэлгээ, цаг үеийн онцлогт тохируулан сайжруулах шаардлага харагдаж байна.

Суралцагчдад зориулсан сэтгэл зүй, хууль зүйн чиглэлийн үйлчилгээ байхгүй, албан ёсны үйлчилгээний төвүүд байхгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутныг үеийнхэнтэйгээ адил түвшинд амжилттай суралцах боломжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Дүгнэлт: 5.2 шалгуурыг *бүрэн хангасан* байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг. Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Оюутны байгууллагын үйл ажиллагааг дэмжих, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг урамшуулах, урлаг спортын тэмцээнийг үр дүнтэй зохион байгуулах, оюутанд үзүүлэх үйлчилгээг өргөтгөх, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн ажилд үйлдвэрлэл технологийн сургууль жил бүр тодорхой төсөв хийж, зарцуулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Эдгээр хөтөлбөрт хамрагдаж буй оюутнууд жил бүр “Цусаа бэлэглэе” аян, Дунд голын эрэг дагуух газрын цэвэрлэгээнд сайн дураар оролцдог.

Оюутны хэд хэдэн клубтэй, клубийн үйл ажиллагаанд оюутнууд идэвхтэй оролцдог, сургуулийн, үндэсний, олон улсын чанартай тэмцээнүүдэд амжилттай оролцдог туршлагатай. Үүгээр дамжуулан оюутны зохион бүтээх чадвар, асуудал шийдвэрлэх чадваруудыг хөгжүүлэхийг зорьдог. Бүх шатны уралдаан тэмцээнд оролцсон оюутнуудаа урамшуулдаг урамшууллын тогтолцоо хэрэгжиж хэвшсэн.

Сул тал: Оюутны клубүүдийн үйл ажиллагаа тогтмол боловч шинээр элсэж буй, 1-2-р түвшний оюутнуудад клубийн мэдээлэл дутмаг байдгаас оролцож чаддаггүй тохиолдол гардаг.

Дүгнэлт: 5.3 шалгуурыг *бүрэн хангасан* байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна. ШУТИС-ийн “Сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” (sbh.edu.mn/userfiles/files/surgaltiin%20juram.pdf)

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Сургалтын албан дээр тухайн бүрэлдэхүүн сургуулийн зөвшөөрлөөр оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулж, зохих журмын дагуу шийдвэрлэдэг.

Сул тал: Идэвхтэй суралцагчийн тоог нэмэгдүүлэх, шалтгаангүйгээр сургуулиа орхих, жилийн чөлөө авч буй оюутнуудын судалгааг хийж, эргэх холбоотой зохион байгуулсан ажил дутмаг байна.

2016-2017 онд сургуулиас гарсан оюутны тоо их байгаа нь хөтөлбөрийн өөрчлөлттэй холбоотой гэж дүгнэжээ. Оюутан анх элсэх үед батлагдсан хөтөлбөрийн дагуу суралцах ёстой бөгөөд тайланг уншихад шаардлагатай хийгдсэн өөрчлөлтийг оюутанд танилцуулалгүй хэрэгжүүлж, оюутны сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд хүндрэл учруулсан гэж харагдахаар байна.

Дүгнэлт: 5.4 шалгуурыг *бүрэн хангасан* байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

Төгсөгчдөд олгосон диплом, дипломын хавсралтад хөтөлбөрийн нэр, индекс, судалсан хичээл, бакалаврын судалгааны ажлын сэдэв, гүйцэтгэлийг харгалзах оноо, үсгэн дүнгээр бичиж баталгаажуулсан байна. Диплом, дипломын хавсралтыг монгол, монгол бичиг, англи хэлээр хэвлэсэн байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Сургалтын албан дээр тухайн бүрэлдэхүүн сургуулийн зөвшөөрлөөр оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулж, зохих журмын дагуу шийдвэрлэдэг.

Сул тал: 2016-2017 онд сургуулиас гарсан оюутны тоо их байгаа нь хөтөлбөрийн өөрчлөлттэй холбоотой гэж дүгнэжээ. Оюутан анх элсэх үед батлагдсан хөтөлбөрийн дагуу суралцах ёстой бөгөөд тайланг уншихад шаардлагатай хийгдсэн өөрчлөлтийг оюутанд танилцуулалгүй хэрэгжүүлж, оюутны сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд хүндрэл учруулсан гэж харагдахаар байна.

Шилжилт хөдөлгөөнд сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө болон төлбөрийн өөрчлөлт нь гол нөлөөг үзүүлж . 2016-2017 оны хичээлийн жилүүдэд уг хөтөлбөрөөр суралцагчдын шилжилт хөдөлгөөнийг судлахад нийт чөлөөтэй 35, шилжсэн 5, сургуулиас гарсан 20, сураггүй болсон 168 оюутан байна.

Дүгнэлт: 5.5 шалгуурыг *бүрэн хангасан* байна.

ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Элсэлтийн журам, бусад холбогдох дүрэм журмын дагуу элсэлтийг зохион байгуулж, вэб хуудсаар дамжуулан хөтөлбөрийн сурталчилгааг хийдэг боловч гарын авлага, зөвлөмж боловсруулж түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж, ЕБС-ийн төгсөгчдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон маркетингийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Идэвхтэй суралцагчийн тоог нэмэгдүүлэх, шалтгаангүйгээр сургуулиа орхих, амжилтгүй судлах жилийн чөлөө авч буй идэвхгүй оюутнуудын судалгааг хийж, эргэх холбоотой ажлуудыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Өөрийн үнэлгээний 3 тайланд 5.5 дэд бүлэг (Төгсөлтийн баримт бичиг)-т холбогдох баримт бичиг, диплом, дипломын хавсралтын талаар тайлагнаагүй байна.

Сургалтын хөтөлбөрийг сайжруулалт хийж, батлагдаж амжаагүй байхад нь хэрэгжүүлдэг, хэрэгжиж эхлэх хугацааг тодорхой заадаггүйгээс оюутнуудын хичээл сонголт өөрчлөгдөх, ачаалал ихсэх зэрэг асуудал үүсэж байгааг холбогдох дүрэм журмын дагуу оюутанд ээлтэй байдлаар шийдвэрлэж байх нь зүйтэй.

Дүгнэлт: “Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Оюутны элсэлтийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн маркетингийг элсэгч болон 1-р түвшний оюутны нас, сэтгэхүйн онцлог, цаг үедээ тохирсон хэлбэрээр, үр өгөөжтэй зохион байгуулах
2. Сургуулиас гадагш чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх
3. ШУТИС-ийн хэмжээнд суралцагчид хууль зүй, сэтгэл судлалын чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох
4. Дипломын хавсралтад хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тусган оруулах

Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрт ажиллаж байгаа багш нар нь сүүлийн үед гадаад болон дотоодод мэргэжил дээшлүүлсэн багш нарын бүрэлдэхүүнтэй байна. Багш нарын 63% нь эрдмийн зэрэг цолтой багш, 36% нь профессор, дэд профессорын зэрэгтэй багш нартай байна.

Багшийг шинээр ажилд авахдаа ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шалгаруулж авдаг журамтай юм байна.

Хөтөлбөрийн багш нар нь үр дүнд суурилсан сургалтын CDIO арга зүй эзэмшсэн багш нартай байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багш нарыг шалгаруулж авах тогтсон журамтай бөгөөд салбартаа тэргүүлэх багш нарын бүрэлдэхүүнтэй байна. Багш нар нь бүгд CDIO арга зүй эзэмшсэн байна.

Дүгнэлт: 6.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

2019 онд боловсруулагдан батлагдсан ШУТИС-ийн багш хөгжлийг дэмжих хөтөлбөртэй.

ШУТИС-ийн БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ нь 2015 оны 11-р сард Ректорын А/238 тоот тушаалаар байгуулагдсан бөгөөд Багш хөгжлийн төвөөр дамжуулан багшийг эрдэм шинжилгээ болон сургалт заах арга зүйн талаар хөгжүүлдэг юм байна. <http://fdc.edu.mn/>

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багш хөгжлийн хөтөлбөртэйгөөр барахгүй 2030 оны хүртэлх төлөвлөгөөтэй бөгөөд түүгээр сургах арга зүй, эрдэм шинжилгээ, инновац болон хувь хүний ур

чадваруудыг хөгжүүлдэг.

Дүгнэлт: 6.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

ШУТИС-ийн Технологи дамжуулах төв нь багш, судлаачид, оюутан, зохион бүтээгчдийн ноу-хау, судалгааны үр дүнг оюуны өмчийн эрхийн хамгаалалтаар баталгаажуулан эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжих замаар их сургуульд инновац, энтрепренёр соёлыг төлөвшүүлэх зорилготой ажиллаж байна.

ШУТИС-ийн МехТС-д эрдэм шинжилгээний төв болон профессорын багууд ажиллаж байгаа бөгөөд түүгээр дамжуулан багш нар нь судалгааны ажилд хамрагдан ажиллаж байна.

Багш хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан судалгаа шинжилгээний ажил хийхийг дэмжиж ажилдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багш нарын судалгаа шинжилгээний ажлыг дэмжиж ШУТ дамжуулах төв, эрдэм шинжилгээний төв, профессорын багууд ажилдаг бөгөөд түүгээр дамжуулан судалгаа шинжилгээг сайн хийдэг байна.

Дүгнэлт: 6.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

Багшийн өөрийн үнэлгээний журам, Багш нарын аттестатчиллын 100 оноо бүхий шалгуур, Багшийн хөндлөнгийн үнэлгээний шалгуур, журамтай.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багшийн заах арга зүй болон эрдэм шинжилгээ судалгааны талаар байнга тайлан бичиж хөтөлбөр болон өөрсдийгөө сайжруулж ирдэг байна. Үр дүнд суурилсан сургалтын CDIO арга зүйг нэвтрүүлсэн бөгөөд түүний багшийг үнэлэх үнэлгээг нэвтрүүлсэн байна.

Сул тал: Үр дүнд суурилсан сургалтын CDIO арга зүйг нэвтрүүлсэн хэдий ч цөм хичээлийг зааж байгаа багш нарыг урамшуулах болон жирийн хичээл зааж байгаа багшаас ялгаатай үнэлдэг тогтолцоо байхгүй байна.

Дүгнэлт: 6.4 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүнээр бүрэн хангагдсан бөгөөд багш нарыг дэмжих, үнэлэх талаар нэгдсэн арга хэмжээнүүдтэй бөгөөд багш хөгжлийн хөтөлбөр, багшийн хөгжлийн төвөөр дамжуулан багшийг хөгжүүлж сайжруулж иржээ.

Багшийн үйл ажиллагааг хөндлөнгийн болон өөрийн үнэлгээгээр үнэлж дүгнэдэг энэ нь CDIO арга зүйг нэвтрүүлсэн жишиг хөтөлбөр юм.

Багш судлаачид нь өөрийн сургуулийн сургалтын материаллаг бааз, лаборатори тоног төхөөрөмжид тулгуурлан судалгаа шинжилгээ хийх боломжтой. Гэвч цөм хичээл, CDIO арга зүйг нэвтрүүлэх ажлын хүрээнд багшийн ажиллах цаг маш их байдаг тул бусад ажил тэр

тусмаа судалгааны ажил хийх цаг хугацаа маш хүрэлцдэггүй.

Дүгнэлт: “Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Цөм хичээлийг зааж байгаа багшийн цагийн ачааллыг тэнцвэртэй байлгах
2. CDIO арга зүйг нэвтрүүлж байгаа арга багш нарыг дэмжих урамшуулах
3. Багш нарыг үйлдвэрлэл болон бусад байдлаар дадлагажуулах, тэдгээрийг дэмжих

Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

2018 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог стандартын дагуу нэвтрүүлсэн гэрчилгээг 3 жилийн хугацаатай авсан.

2016 оноос CDIO загварыг сургалтад амжилттай хэрэгжүүлж эхэлсэн.

Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг боловсруулан, батлуулж, мөрдөж ажилладаг.

МехТС-ийн сургалтын хөтөлбөрүүдийн дотоод чанарын баталгаажуулалт буюу хөндлөнгийн хяналтыг Чанарын менежментийн зөвлөл удирдан ажилладаг.

Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлыг хариуцсан Чанарын менежер тус сургуульд ажилладаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрүүдийн зохицуулалт болон сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад чиглэсэн дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизм бүрдсэн.

Дүгнэлт: 7.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Баримт нотолгоо:

МехТС нь сүүлийн 5 жил төгсөгчдийн мөшгөх судалгааг бүх хөтөлбөр, мэргэжлээр зохион байгуулж ирсэн.

Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа хийгддэг. Төгсөгчдийн ажил эрхлэлт өндөр (75-95%).

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: МехТС нь төгсөгчидтэйгөө холбоотой ажиллаж, хөтөлбөрийг сайжруулахад хамтран ажилладаг.

Дүгнэлт: 7.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Баримт нотолгоо:

ШУТИС нь 2018 оны 6-р сарын 20-нд БМИҮЗ-өөс 4 дэх удаагаа 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн. Авто инженер болон бусад хөтөлбөрүүдийн хувьд чанарын үнэлгээ, баталгаажилттай холбоотойгоор PDCA үнэлгээ болон SWOT шинжилгээ хийгдсэн.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: МТС нь “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан”-г 10 шалгуур үзүүлэлтээр гарган дүгнэснээс гадна магадлан итгэмжлэлд хамруулах хөтөлбөрүүдийг ШУТИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2014 оны 6-р сарын 20-ны хурлаар хэлэлцүүлж, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага хангасан талаар дүгнэлтийг гаргуулж, магадлан итгэмжлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Монгол улсын Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн сайдын тушаалаар үндэслэн Металлурги, машин үйлдвэрлэл, метал боловсруулалтын салбарын мэргэжилтэнгүүдэд зөвлөх болон мэргэшсэн инженерийн сургалтыг явуулдаг.

Сул тал: Олон улсын түвшинд инженер техникийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын байгууллага, хөтөлбөрт нийтлэг байдлаар ямар шаардлага тавьдаг, үнэлгээ дүгнэлт хийдэг эсэх талаар мэдээлэл тусгагдаагүй.

Дүгнэлт: 7.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

МехТС нь 2016 оноос CDIO загварыг сургалтад хэрэгжүүлж эхэлснээс гадна 2018 оноос ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог стандартын дагуу нэвтрүүлэн ажиллаж байгаа нь хөтөлбөрийн дотоод чанарыг баталгаажилтыг ханган ажиллах боломжийг бүрдүүлж байна.

Хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотой тогтмол хийгдэх нэг ажил нь хичээлийн үнэлгээ буюу оюутны сэтгэл ханамжийн судалгааг улирал бүрийн эцэст гаргаж, судалгааны үр дүнд үндэслэн тодорхой сайжруулалт хийгдэж байх шаардлагатай. Сургууль дээр ажиллах хугацаанд цаг хугацааны хувьд амжаагүй учир энэ талаар бүрэн мэдээлэл авч амжаагүй. Тухайлбал, санал асуулгын асуултууд нь ямар бүтэцтэй, аль хэсэгт оюутнуудын сэтгэл ханамж сайн эсвэл тааруу байгаа, тааруу байгаа шалтгаан нь юутай холбоотой, сургуульд заагдаж буй хичээлүүдийн хувьд дундаж үнэлгээ ямар байгаа гээд олон мэдээллийг харж, үнэлэлт хийх боломжтой байдаг.

Дүгнэлт: “Чанарын үнэлгээ, баталгаажилт” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотойгоор хичээлийн үнэлгээ буюу оюутны сэтгэл ханамжийн судалгааг улирал бүрийн эцэст хийж, судалгааны үр дүнд үндэслэн тодорхой сайжруулалт хийж хэвших
2. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны стандарт ISO21001:2018 стандартыг нэвтрүүлэх.
3. Олон улсын түвшинд инженер техникийн мэргэжилтэн бэлтгэх байгууллага, хөтөлбөрт нийтлэг байдлаар ямар шаардлага тавьдаг, үнэлгээ дүгнэлт хийдэг эсэх судлан, ирээдүйд хөтөлбөрийг олон улсын түвшинд хөндөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан шаардлага (2)	Хэсэгчлэн хангасан шаардлага (1)	Хангаагүй шаардлага (0)	ҮНЭЛГЭЭ
1-А	Авто инженер хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			Бүрэн хангасан
1-Б	Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			Бүрэн хангасан
1-В	Металл боловсруулах технологи хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1, 2.2, 2.3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1, 3.2, 3.3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5			Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	6.1, 6.2, 6.3, 6.4,			Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.1, 7.2, 7.3			Бүрэн хангасан
Нэгдсэн дүгнэлт		Хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.			

Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлагын тэмдэглэлд үндэслэн шинжээчийн баг “Авто инженер”, “Үйлдвэрлэлийн автоматжуулалт”, “Металл боловсруулах технологи” бакалаврын хөтөлбөр нь БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг “**Бүрэн хангасан**” гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, чанарыг цаашид сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг өгч, шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨМЖ

<p>Шалгуур 1-А: Авто инженер хөтөлбөрийн төлөвлөлт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Авто машины хөгжлийн 4 дүгээр үеийн техникийн онцлог, зарчимд үнэлгээ хийж хөтөлбөрийн хөгжлийн бодлогыг тодорхойлох 2. Дугуйт болон гинжит техник, цахилгаан болон хос хөдөлгүүртэй техникийн ашиглалтын онцлогийг харгалзан үзэж мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг хөгжүүлэх асуудалд судалгаа хийх 3. Төгсөгчдийн хөрвөж ажиллах ур чадвар, дадлага олгоход CDIO-ийн цөм хичээлийн цагийн багтаамжийг нэмэгдүүлэх. 4. Ажил олгогчийн судалгааны асуулгыг дэлгэрүүлэн “Авто инженер” хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтад заагдсан сургалтын зорилго, зорилтууд хоорондын уялдаа, холбооны дагуу үнэлгээ хийлгэх
<p>Шалгуур 1-Б: Үйлдвэрлэлийн автоматжуулалт хөтөлбөрийн төлөвлөлт</p>	<ol style="list-style-type: none"> 5. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, засгийн газрын зорилтот хөтөлбөрүүдтэй уялдуулах 6. Төгсөгчдийн судалгааг авахдаа төгсөөд хамгийн багадаа 2-3 жил болсон мэргэжлийн хэрэгцээ, чадамжийг ойлгосон төгсөгчөөс авах хэрэгтэй энэ нь судалгааг илүү бодитой үнэ зөв болгоно. 7. Хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөллийг оролцуулах
<p>Шалгуур 1-В: Металл боловсруулах технологи хөтөлбөрийн төлөвлөлт</p>	<ol style="list-style-type: none"> 8. Хөтөлбөрийн нэр, индексийг тодорхой болгох 9. Мэргэжил сурталчлах, мэргэжлийн онцлог, ирээдүйн төлвийг ойлгуулах, мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах 10. 2018 оноос хойш төгсөгчдийн ажлын байрны судалгаа, төгсөгчдийн ур чадаврын судалгааг хийх
<p>Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа</p>	<ol style="list-style-type: none"> 11. CDIO сургалтад бүх багш нарыг жигд хамруулж, өөрсдийн заадаг хичээлүүддээ идэвхтэй сургалтын арга, үр дүнд суурилсан сургалтын арга барилыг нэвтрүүлж, харилцан суралцаж, туршлага солилцох 12. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн хичээлийн багшийг сонгох боломжийг нэмэгдүүлэх
<p>Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл</p>	<ol style="list-style-type: none"> 13. Багш нар хичээлийн агуулгыг шинэчлэн, шинэ багаж төхөөрөмжийг сургалтад нэвтрүүлж байгаа шинэчлэлтэй холбоотойгоор шинээр сурах бичиг, гарын авлага, бүтээл туурвих 14. Механик, тээврийн сургуулийн багш нарын бүтээлийг хэвлэх эрдэм шинжилгээ судалгааны сэтгүүлтэй болох 15. Худалдан авалтаар мэргэжлийн хичээлийн хүрээнд судлах ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх 16. Мэргэжлийн хичээл бүр дээр виртуал орчин, бодит байдалд ойртсон зохиомж, бодлогууд, даалгавруудыг дуурайлган үзүүлэх, бодитоор харуулах боломжтой сургалтын материалыг E контентын түвшинд боловсруулах ажлыг эрчимжүүлэх.
<p>Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p>	<ol style="list-style-type: none"> 17. 2.ЕБС-ийг төгсөгчдийн тоо зарим жилүүдэд цөөн байдагтай холбоотойгоор элсэгчдийг идэвхжүүлэх, хөтөлбөрөө сурталчлах ажлуудыг тодорхой төлөвлөгөөтэйгөөр явуулах.

<p>Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа</p>	<p>18. Оюутны элсэлтийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн маркетингийг элсэгч болон 1-р түвшний оюутны нас, сэтгэхүйн онцлог, цаг үедээ тохирсон хэлбэрээр, үр өгөөжтэй зохион байгуулах</p> <p>19. Сургуулиас гадагш чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх</p> <p>20. ШУТИС-ийн хэмжээнд суралцагчид хууль зүй, сэтгэл судлалын чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох</p> <p>21. Дипломын хавсралтад хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тусган оруулах</p>
<p>Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа</p>	<p>22. Цөм хичээлийг зааж байгаа багшийн цагийн ачааллыг тэнцвэртэй байлгах</p> <p>23. CDIO арга зүйг нэвтрүүлж байгаа арга багш нарыг дэмжих урамшуулах</p> <p>24. Багш нарыг үйлдвэрлэл болон бусад байдлаар дадлагажуулах, тэдгээрийг дэмжих</p>
<p>Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<p>25. Хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотойгоор хичээлийн үнэлгээ буюу оюутны сэтгэл ханамжийн судалгааг улирал бүрийн эцэст хийж, судалгааны үр дүнд үндэслэн тодорхой сайжруулалт хийж хэвших</p> <p>26. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны стандарт iso 21001:2018 Чанарын менежментийн тогтолцоог стандартыг нэвтрүүлэх.</p> <p>27. Олон улсын түвшинд инженер техникийн мэргэжилтэн бэлтгэх байгууллага, хөтөлбөрт нийтлэг байдлаар ямар шаардлага тавьдаг, үнэлгээ дүгнэлт хийдэг эсэх судлан, ирээдүйд хөтөлбөрийг олон улсын түвшинд хөндөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах.</p>

Шинжээчийн багийн ахлагч	Т.СОРОНЗОНБОЛД
Шинжээчийн багийн гишүүн	Ж.МӨНГӨН
Шинжээчийн багийн гишүүн	Л.АЛТАНГЭРЭЛ
Шинжээчийн багийн гишүүн	Д.САРАНГЭРЭЛ

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс**I. Багш нарын нэрс**

№	Багшийн нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Майл хаяг

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс, түвшин	Сонгосон байдал	Утас	Майл хаяг
		1	Орон нутгийн		
		2	Хөгжлийн бэрхшээлтэй		
		3	Клубийн гишүүн		

III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчийн нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж

ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж